

БАТЛАВ:  
МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ ХХК-ИЙН  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЗРЫН ДАРГА



Техникийн нөхцөл

Дугаар: ТН-А24/2023

Захиалагч байгууллага : “Баянхонгор аймгийн нийгмийн даатгалын хэлтэс”

Объектыннэр : Нийгмийн даатгалын шинэ байр

Харилцах утас : 70442162

1.Байршил : БХР-Аймгийн Номгон 1-р баг

2.Холбооны хэрэгцээ :Барилгын холбооны гадна сувагчлал, шилэн кабель

3.Техникийн үндсэн нөхцөл :

Баянхонгор аймгийн нийгмийн даатгалын хэлтэсийн барилгад кабель татах.Мэдээлэл холбооны сүлжээ”ХХК”-ийн ХШ-6 хуваарилах шүүгээнээс ТПП20х2 хосын 600м сувагчлалын кабель татаж мөн МХС-ийн 84-р худгаас 350м шилэн кабель татаж 150м сувагчлал 2ш худаг шинээр хийж сувагчлалаар шилэн болон физик кабель татаж гадна оруулга хийх.Барилгад сувагчлалын яндан суурилуулахад зориулж /\*-газрын түвшнээс доош 80 см-т, 20х20 см хэмжээтэй нүх гаргаж цүтгалт хийсэн байх.

Жич: Холбооны инженерийн байгууламжуудын угсралт суурилуулалтын ажлыг Монгол улсын MNS5207:2011, MNS5278:2003, MNS5317:2011, MNS5279:2011, MNS5280:2011, MNS5016:2001, MNS5884:2008, MNS4907:2005, MNS5208:2002 зэрэг бусад холбогдох стандартуудыг мөрдөж технологийн дагуу хийж гүйцэтгэх шаардлагатай.

4. Техникийн тусгай нөхцөл:

4.1.Угсралтын ажил эхлэхээс өмнө зураг төсөв техникийн нөхцөлийн дагуу хийгдсэн эсэхийг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Баянхонгор аймгийн газрын кабель шугамын инженерээр /утас 99442188 / хянуулан баталгааг авсан байх

4.2.Газар шорооны ажил гүйцэтгэхдээ кабель шугамын инженер болон Ерөнхий инженерээр шалгуулан далд ажлын акт үйлдэж, хүлээн авах ажлын актан д хавсаргах

4.3. Угсралтын газар шорооны ажил эхлэхийн өмнө хотын инженерийн шугам сүлжээний техникийн ашиглалт хариуцдаг мэргэжлийн байгуулагуудад трассын зургийг хянуулан зөвшөөрөл авсан байх.

4.4.Кабель шугамын угсралт болон газар шорооны ажлыг эхлэхдээ Ерөнхий инженерээс албан ёсны мэдэгдлийг авч кабель шугамын инженерийн удирдлагадор гүйцэтгэнэ.

4.5. Угсралтын ажлыг гадна агаарын температур -5 градусаас илүүгүй хүйтний нөхцөлд гүйцэтгэх

4.6. Шинээр татсан кабельд тэмдэг тэмдэглээг бүрэн хийсэн байх

4.7. Угсралтын ажлын явцад захиалагч, ашиглалтын байгууллагатай хамтарч хяналт тавьж угсралтын технологийн шаардлагыг бүрэн хангуулсан байна.

4.8. Хэрэглэгч холбох нөхцөлийг бүрдүүлэхийн тулд барилгын дотор монтажийн угсралтыг Монгол улсын стандарт MNS5471:2005 ерөнхий шаардлагын дагуу хийгдсэн тохиолдолд гадна холбооны угсралтын ажлыг хүлээж авна.

4.9. Шинээр хийгдсэн холбооны худаг сувагчлал болон кабель шугамнь хотын телефоны кабель шугамын сүлжээнд холбогдох тул эдэлбэр газар суурилуулагдсан холбооны сувагчлал болон кабелийг механик гэмтлээс хамгаалах

4.10.Шинээр хийсэн худаг сувагчлал болон газрын шилэн кабелийн кадастрын зураглал болон байгаль орчны үнэлгээг гаргуулан тухайн аймгийн зураг зүйн нэгдсэн санд оруулах

4.11.Шинээр хийгдсэн газрын шилэн кабель болон сувагчлалыг тухайн харъяалагдах аймгийн кадастарын зураг зүйн газарт хүлээлгэн өгсөн байх

5. Гүйцэтгэгч нь ХХЗХорооноос олгогдсон тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай.

6.Угсралтын ажил дууссаны дараа хэмжилт шалгалт хийлгэж тогтоосон журмын дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Баянхонгор аймгийн газарт техникийн актаар хүлээлгэн өгсний дараа сүлжээнд холбох зөвшөөрлийг авна.Энэхүү Техникийн нөхцөл олгосон өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй

Хянасан: Ерөнхий Инженер...../Ц.Одонтуяа/

Боловсруулсан: КШ Инженер...../Б.Бат-Эрдэнэ/





БАТЛАВ : ХОЛБООНЫ ГАЗРЫН ЗАХИРАЛ /Д.БУДРАГЧАА/

ТЕХНИКИЙН ДААЛГАВАР  
Дугаар 20230922

Баянхонгор аймаг

2023/09/22

**1. Барилгын байршил:**

Баянхонгор аймаг Баянхонгор сум

**2. Техникийн даалгавар бичих болсон шалтгаан үндэслэл:**

Баянхонгор сумын Номгон 1-р баг Чандмань-3 гудамж 308 тоот газрын суурин дээр 3 давхар төрийн захиргааны зориулагатай барилгыг телефонжуулах, интернэтийн сүлжээгээр хангах болон кабелийн телевизийн оруулгыг оруулж монтажлах.

**3. Техникийн үндсэн нөхцөл:**

МХС ХК-ийн техникийн нөхцөлийг үндэслэн мэргэжлийн байгууллагын удирдамж зааварын дагуу Шилэн болон физик кабель татан дотор монтажны хуваарилах хайрцагт FDF-ийг байршуулах, хувиарлах хайрцагнаас бүх өрөөрүү интернет, кабелийн телевиз, телефоны утаснуудыг сувагчлал болон хоолойгоор сүвлэж тараах.

1. Оффисын өрөө бүрт UTP кабелиар интернетийн холболт оруулах
2. Өрөө бүрт телефоны утас оруулга оруулах
3. Өрөөний хананд интернет, кабелийн телевиз, телефоны төгсгөлийн залгуурыг хөдөлгөөнгүй суулгах.
4. Монтаж холболтыг бүрэн хийж шалгасан байх.
5. Барилгын газардуулга хийж Ом-н эсэргүүцэл норм стандартад нийцсэн хэмжилт хийсэн байна.

**4. Шаардагдах материал:**

- П274 маркын телефоны утас
- Дотор монтажны кабель / UTP/
- Дотор монтажны утас сүвлэх гуурсан хоолой
- Давхар хоорондын гуурсан 100-н пластмасан хоолой
- Интернет, телефон, кабелийн тв-ийн төгсгөвч

**5. Зураг төсөвт зайлшгүй тусгах шаардлагатай онцгой нөхцлүүд:**

Шинээр баригдах барилгын интернэтийн гаднах оруулга дотоод монтаж, өрөө бүрийг интернэтэд холбох, телефонжуулах ажлын зардлыг төсөвт бүрэн тусгаж технологийн дагуу хийсэн байх шаардлагатай.

**6. Ажлын гүйцэтгэлийн явцад мэргэжлийн заавар зөвлөгөө авч хамтарч ажиллах.**

**7. Энэхүү техникийн даалгаварыг гүйцэтгэхдээ Монгол улсын Харилцаа холбооны MNS-5471:2005, 2012, 2016 стандартыг баримтална. Холбогдох материалыг хавсралт хэсгээс харна уу**

**8. Гүйцэтгэгч : "ОЧИНТААБ" ХХК**

**9. Зураг төсвийг : "....."ХХК**

**10. Захиалагч: Иргэн "Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс"**

Техникийн даалгавар боловсруулсан:

Ахлах инженер ..... /Г.Вандансанги /70444024, 88444190/